

ОРШИЛ БИЧИХИЙН УЧИР...

МУИС-ийн Монгол Судлалын Төв (Centre for Mongol Studies) нь эрдэм шинжилгээний жил тутмын хэвлэл - АСТА MONGOLICA сэтгүүлийн тэргүүн боть нийтлэгдсэнээс хойш нэгэн хичээлийн жил өнгөрч уг сэтгүүлийн хоёдугаар ботийг толилуулж байна.

I. Энэхүү хугацаанд МУИС-ийн Монгол Судлалын Төв (МСТ) эрдэм шинжилгээ, сургалтын хүрээнд гүйцэтгэсэн ажлынхаа талаар товч танилцуулахад:

I. 1. Монголын судлалын ховор нандин дурасхалыг судлан нийтлүүлэх ажлын хүрээнд MONUMENTA MONGOLICA хэмээх дурсгалт бичигийн чуулганы эхний гурван дэвтэрийг нийтлэн гаргасан болно. Үүнд:

MONUMENTA MONGOLICA: Том I :

Ц. Шагдарсүрэн, Lee Seong-Gyu, *Byamba-yin Asarayǎ nere(tü)-yin teüke*, Улаанбаатар, 2002, 298 тал.

MONUMENTA MONGOLICA: Том II :

Ш. Чоймаа, *Ха(а)дын үндсэн хураангуй Алтан товч*, Улаанбаатар, 2002, 331 тал.

MONUMENTA MONGOLICA: Том III :

Ё. Жанчив, *Дөрвөлжин үсгийн монгол дурсгал*, Улаанбаатар, 2002, 195 тал.

Дээр дурдсан цувралын эхний хоёр дэвтэрт ганц хувь хадгалагдаж байсан "Асрагч нэрт(ийн) түүх", "Хураангуй Алтан товч" хэмээх дурсгалыг уг эхээр нь судлагааны нь хамт анх удаа эрдэм шинжилгээний гүйлгээнд оруулсан болно. Хэдийгээр энэхүү цувралаар гараагүй боловч эхбичиг судлах бидний ажлын хүрээнд

Ш. Чоймаа, *"Монголын нууц товчоон", Луесанданзаны "Алтан товч"* - Эхийн харьцуулсан судалгаа, Улаанбаатар, 2002, 188 тал.

бүтээл нийтлэгдсэнийг хэлэх ёстой. Үүний дээр тус Төвөөс гарсан зарим бүтээл нь Боловсрол, соёл, шинжлэх ухааны Яамнаас шалгаруулсан 2002 оны ШУ-ны шилдэг бүтээлийн тусгай шагнал, МУИС-ийн Буддийн Соёлын төвийн шагналыг тус тус хүртжээ.

I. 2. МУИС-ийн МСТ-д ХБНГУ-ын Германы Эрдэмийн Солилцооны Алба (DAAD) байгууллагаас судлагааны ажлыг дэмжиж 15 сая төгрөгийн техник төхөөрөмжийн буцалтгүй тусламжийг үзүүлсэн бөгөөд үүний дүнд ЭШ, сургалтын ажлын нөхцөл эрс сайжирч "Дэлхийн монгол судлалын сан"-г бүрдүүлэх ажил эхлээд байна.

I. 3. Монгол бичигийн үндэсний хөтөлбөрийн хүрээнд МУИС-ийн бүрэлдэхүүний бүх нэгжийн цахим тооцоолуурыг монгол бичигийн сангаар хангасан болно.

I. 4. Дурдсан хугацаанд МСТ нь Францын Монгол судлалын төвтэй хамтран *Монгол франц толь* болон эхбичиг судлалын салбараар ажиллаж, францын номын сангуудад хадгалагдаж буй монголын судлалд холбогдох шинэ баримтыг хайн олох, судлах ажлыг хийж ирсэний¹ зэргээ манай эрдэмтдийн сүүлийн үеийн судлагааны үр дүн - Монгол хийгээд Алтайсудлалын чиглэлээр бичсэн бүтээлүүд Япон, АНУ-ын ЭШ-ний хэвлэлүүдэд нийтлэгджээ. Мөн 2001 оны зун БНСУ-ын Монгол судлалын нийгэмлиг (The Korean Association for Mongol Studies), Солонгосын Өргөн нэвтрүүлгийн нийгэмлиг (The Korean Association of Broadcasting Studies)-тэй хамтран Улаанбаатар хотноо зохион байгуулсан Эрдэм шинжилгээний хуралд тавьсан Монголын талын эрдэмтдийн илтгэл хэвлэгдэн гарсан болно².

I. 5. Энэ хугацаанаа МСТ-д академич Ринчений зарим гар бичмэл болон зохиолын эмхитгэл, Я. Цэвэлийн *"Монгол хэлний товч тайлбар толь"*-ийн нэмж зассан хоёрдугаар хэвлэл болон МСТ-ийн дараагийн цуврал бичигүүдийн хэвлэлд бэлтгэх ажлыг гүйцэтгэж байна.

II. Жил тутамын АСТА MONGOLICA сэтгүүлийн толилуулан бүхий энэ дугаарт монгол болон гадаадын монголч эрдэмтдийн шинэ бүтээл, тэмдэглэл, шүүмж зэргийг оруулав. Мөн гадаад хэлээр эхлэн нийтлэгдсэн манай эрдэмтдийн зарим бүтээлийн монгол эхийг эхлэн нийтлэж байна.

Үүний хажуугаар ахмад үеийн монголч эрдэмтдийн олны хүртээл болж амжаагүй буюу монгол уншигчдад тэр бүр олдоод байхгүй сан хөмрөгөөс танилцуулдаг хэсэгтээ³ академич Б. Я. Владимирцовын 1928 онд Халимагт уншсан лекц, хэлсэн үг тэргүүтэнийг Г. И. Михайловын бэлтгэсэнээр оруулж байна. Энэ баримт Халимагт хадгалагдаж байгаад төсөрхөн олон мэдэгдэж эхлэсэн бөгөөд эндээс монгол хэл, монгол бичигийн хэл, түүний нийгэмийн үүрэгийн талаар хэрхэн үзэж дүгнэж байсаныг үзэж болно. Академичийн энэхүү дүгнэлт нь монгол хэл, бичигийн талаар янз бүрийн ойлголттой байгаа одоо үед ч анхааран үзүүштэй олон зүйлийг хамарсан тул ийнхүү сонгож авсан болно.

МСТ-ийн Эрдэмтэн нарийн бичигийн дарга

Цэвэлийн Улагарсүрэн

2003 оны 5-р сар.
Улаанбаатар хот.

¹ Францаас олдсон шинэ дурасхал баримтын талаархи тэмдэглэлийг эл дугаараас үзнэ үү.

² *Mongolian Studies* (The Korean Association for Mongol Studies), No. 12, 2002, Seoul.

³ Түрүүчийн дугаарт профессор Чой. Лувсанжав багштань *A Contrastive analysis of the Morphological Structure of words in Mongolian and English languages* хэмээх бүтээлийн хураангуйг анх нийтийн хүртээл болгосон билээ.